



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2026/081/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Баянхонгор хот
2026.02.25

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 99007576 Цахим хаяг: Munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер: М.Алтантуяа
Утас: 99061829 Цахим хаяг: Altantuyam@audit.gov.mn
Аудитор: А.Адилзаяа
Утас: 80870886 Цахим хаяг: Adilzayaa@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	Error! Bookmark not defined.
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.5.1 Завсрын аудит хийгдээгүй болно.	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
5.1 Зөвлөмж	Error! Bookmark not defined.
5.2 Албан шаардлага	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

「 БАЯНХОНГОР СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Ж.БЯМБАСҮРЭН
ТАНАА

2026.08.25 № 2/100

танай _____-ны № _____-т

「 **Өөрчлөлтгүй дүгнэлт** 」

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлын онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Баянхонгор сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдааны 5/30 дугаар тогтоолоор сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны төрийн захиргаа, төрийн үйлчилгээ болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийг 100 хувиар тогтоосон байгаа нь орон нутагт ажиллаж байгаа бусад албан хаагчдын орон нутгийн нэмэгдлийн хувь хэмжээнээс харилцан адилгүй, ялгаатай нөхцөл байдал үүсгэсэн байна.

Аудитын гол асуудал

6426050314

/2026 он/1. бичиг хэрэг/тоот/2. а4-
албан тоот.docx

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Тайлант онд төсөв хязгаарлагдсанаас 4.311,6 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудал

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Б.МӨНХБАТ



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	22,830,053.00	23,395,929.25
33	АВЛАГА	1,403,160.00	219,786.25
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,403,160.00	219,786.25
35	БАРАА МАТЕРИАЛ	21,426,893.00	23,176,143.00
354	Хангамжийн материал	21,426,893.00	23,176,143.00
35410	Бичиг хэргийн материал	1,971,100.00	2,471,100.00
35420	Аж ахуйн материал	1,939,250.00	3,188,500.00
35430	Сэлбэг хэрэгсэл	5,400,000.00	5,400,000.00
35450	Барилгын засварын материал	820,010.00	820,010.00
35470	Бусад хангамжийн материал	11,296,533.00	11,296,533.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	43,295,636.16	41,136,289.16
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	43,295,636.16	41,136,289.16
392	Биет хөрөнгө	42,809,385.67	36,736,289.16
39203	Авто-тээврийн хэрэгсэл	58,100,000.00	18,300,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(48,804,166.99)	(17,029,166.89)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	34,765,900.00	36,349,400.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(17,863,955.85)	(14,899,289.36)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	25,897,140.00	25,570,740.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,758,831.49)	(12,028,694.59)
39217	Ном	473,300.00	473,300.00
393	Биет бус хөрөнгө	486,250.49	4,400,000.00
39301	Програм хангамж	2,675,000.00	9,275,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,188,749.51)	(4,875,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	66,125,689.16	64,532,218.41
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	4,311,600.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	4,311,600.00
413	Өглөг	-	4,311,600.00
4136	Бусад өглөг	-	4,311,600.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	4,311,600.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	66,125,689.16	60,220,618.41
51	Засгийн газрын хувь оролцоо	66,125,689.16	60,220,618.41
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	21,281,230.42	21,281,230.42
51101	Өмч: - төрийн	21,281,230.42	21,281,230.42
512	Хуримтлагдсан үр дүн	42,757,432.90	36,852,362.15
51210	Өмнөх үеийн үр дүн	42,757,432.90	42,757,432.90
51220	Тайлант үеийн үр дүн	-	(5,905,070.75)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,087,025.84	2,087,025.84
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	66,125,689.16	64,532,218.41

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Баянхонгор сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	639,710,166.00	703,347,180.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	25,980.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	25,980.00
120009	Бусад орлого	-	25,980.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	639,710,166.00	703,321,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,570,166.00	11,119,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,570,166.00	11,119,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	633,140,000.00	692,201,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	633,140,000.00	692,201,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	627,980,985.74	705,106,417.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	627,980,985.74	705,106,417.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	586,876,485.69	657,500,228.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	218,552,608.99	299,277,913.39
210101	Үндсэн цалин	109,185,569.69	107,096,963.29
210102	Нэмэгдэл	71,294,363.30	136,975,852.62
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,190,000.00	14,092,644.13
210104	Урамшуулал	27,882,676.00	41,112,453.35
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,357,224.44	36,653,377.85
210201	Тэтгэврийн даатгал	17,653,435.87	25,125,582.28
210202	Тэтгэмжийн даатгал	2,407,156.23	2,784,137.53
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,194,823.63	1,524,064.69
210204	Ажилгүйдлийн даатгал	750,954.65	1,378,518.29
210205	Эрүүл мэндийн даатгал	3,350,854.06	5,841,075.06
2104	Хангамж, бараа материалын зардал	14,374,702.00	19,578,400.00
210401	Бичиг хэрэг	7,475,300.00	5,833,700.00
210402	Тээвэр, шатахуун	6,113,514.00	4,761,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	785,888.00	396,000.00
210404	Ном, хэвлэл	-	3,675,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	4,912,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	3,129,000.00
210604	Урсгал засвар	-	3,129,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,900,000.00	3,120,000.00
210702	Дотоод албан томилолт	3,900,000.00	3,120,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,082,298.00	19,161,748.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,082,298.00	18,005,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	183,348.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	473,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	307,609,652.26	276,579,788.81
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	287,872,750.00	245,191,575.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,150,000.00	17,075,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	17,586,902.26	14,312,913.81
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41,104,500.05	47,606,189.51
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,555,766.00	13,729,500.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	2,610,000.00

Баянхонгор сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	6,555,766.00	11,119,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	33,548,734.05	33,876,689.51
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	33,548,734.05	33,876,689.51
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	11,729,180.26	(1,759,237.56)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	4,145,833.19
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	4,145,833.19
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(4,145,833.19)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	11,729,180.26	(5,905,070.75)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	639,710,166.00	703,347,180.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	25,980.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	25,980.00
120009	Бусад орлого	-	25,980.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	639,710,166.00	703,321,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,570,166.00	11,119,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,570,166.00	11,119,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	633,140,000.00	692,201,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	633,140,000.00	692,201,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	615,032,166.00	687,047,780.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	615,032,166.00	687,047,780.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	573,927,665.95	639,441,590.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	209,797,791.51	297,874,753.39
210101	Үндсэн цалин	90,657,153.21	105,693,803.29
210102	Нэмэгдэл	73,647,358.30	136,975,852.62
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,290,000.00	14,092,644.13
210104	Урамшуулал	34,203,280.00	41,112,453.35
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,070,024.44	36,847,184.10
210201	Тэтгэврийн даатгал	17,607,924.98	25,319,388.53
210202	Тэтгэмжийн даатгал	2,433,556.23	2,784,137.53
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,118,088.63	1,524,064.69
210204	Ажилгүйдлийн даатгал	926,378.14	1,378,518.29
210205	Эрүүл мэндийн даатгал	3,984,076.46	5,841,075.06
2104	Хангамж, бараа материалын зардал	15,245,302.00	19,070,380.00
210401	Бичиг хэрэг	8,345,900.00	5,333,680.00
210402	Тээвэр, шатахуун	6,113,514.00	4,761,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	785,888.00	396,000.00
210404	Ном, хэвлэл	-	3,675,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	4,904,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,600,000.00	3,629,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	500,000.00
210604	Урсгал засвар	2,600,000.00	3,129,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,900,000.00	3,120,000.00
210702	Дотоод албан томилолт	3,900,000.00	3,120,000.00

Баянхонгор сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,091,798.00	15,384,148.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,091,798.00	14,162,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	248,348.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	473,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	299,222,750.00	263,516,125.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	297,072,750.00	246,440,825.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,150,000.00	17,075,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41,104,500.05	47,606,189.51
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,555,766.00	13,729,500.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	2,610,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	6,555,766.00	11,119,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	33,548,734.05	33,876,689.51
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	33,548,734.05	33,876,689.51
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	24,678,000.00	16,299,400.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	24,678,000.00	16,299,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	24,678,000.00	16,299,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	24,678,000.00	16,299,400.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	24,678,000.00	16,299,400.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(24,678,000.00)	(16,299,400.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрс үлдэгдэл	21,281,230.42	2,087,025.84	31,028,252.64	-	54,396,508.90
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	21,281,230.42	2,087,025.84	31,028,252.64	-	54,396,508.90
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	11,729,180.26	-	11,729,180.26
C08	2024 оны 12-р сарын 31-нээрс үлдэгдэл	21,281,230.42	2,087,025.84	42,757,432.90	-	66,125,689.16
D01	2025 оны 12-р сарын 31-нээрс үлдэгдэл	21,281,230.42	2,087,025.84	42,757,432.90	-	66,125,689.16
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-

Баянхонгор сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	21,281,230.42	2,087,025.84	42,757,432.90	-	66,125,689.16
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(5,905,070.75)	-	(5,905,070.75)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	21,281,230.42	2,087,025.84	36,852,362.15	-	60,220,618.41

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

ЭЗА	Үзүүлэлт	Тайлант оны			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	735,303,100.00	658,325,010.49	77,378,089.51	89.48
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	735,303,100.00	658,325,010.49	77,378,089.51	89.48
132001	Орон нутгийн төсвөөс	735,303,100.00	658,325,010.49	77,378,089.51	89.48
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	735,303,100.00	658,325,010.49	76,978,089.51	89.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ	735,303,100.00	658,325,010.49	76,978,089.51	89.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	730,303,100.00	655,715,010.49	74,588,089.51	89.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	307,205,000.00	297,874,753.39	9,330,246.61	96.96
210101	Үндсэн цалин	104,636,000.00	105,693,803.29	2,196.71	100.00
210102	Нэмэгдэл	146,196,000.00	136,975,852.62	7,860,147.38	94.57
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,800,000.00	14,092,644.13	7,355.87	99.95
210104	Урамшуулал	42,573,000.00	41,112,453.35	1,460,546.65	96.57
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,400,600.00	36,847,184.10	1,553,415.90	95.95
210201	Тэтгэврийн даатгал	26,112,200.00	25,319,388.53	792,811.47	96.96
210202	Тэтгэмжийн даатгал	2,982,000.00	2,784,137.53	197,862.47	93.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,626,200.00	1,524,064.69	102,135.31	93.72
210204	Ажилгүйдлийн даатгал	1,536,100.00	1,378,518.29	157,581.71	89.74
210205	Эрүүл мэндийн даатгал	6,144,100.00	5,841,075.06	303,024.94	95.07
2104	Хангамж, бараа материалын зардал	25,361,000.00	19,044,400.00	6,316,600.00	75.09
210401	Бичиг хэрэг	6,346,000.00	5,307,700.00	1,038,300.00	83.6
210402	Тээвэр, шатахуун	8,000,000.00	4,761,400.00	3,238,600.00	59.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	950,000.00	396,000.00	554,000.00	41.68
210404	Ном, хэвлэл	5,109,000.00	3,675,000.00	1,434,000.00	71.93
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,956,000.00	4,904,300.00	51,700.00	98.96
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,089,000.00	13,328,400.00	760,600.00	94.60
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,400,000.00	9,639,400.00	760,600.00	92.69
210602	Тавилга	560,000.00	560,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	3,129,000.00	3,129,000.00	-	100.00
2107	Томилолт, зочны зардал	5,260,000.00	3,120,000.00	2,140,000.00	59.32
210702	Дотоод албан томилолт	5,260,000.00	3,120,000.00	2,140,000.00	59.32
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	34,387,500.00	21,984,148.00	12,403,352.00	63.93
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	32,347,500.00	20,762,800.00	11,584,700.00	64.2
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	500,000.00	-	100.00

Баянхонгор сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210803	Даатгалын үйлчилгээ	160,000.00	-	160,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	280,000.00	248,348.00	31,652.00	88.70
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	23,000.00	-	23,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,077,000.00	473,000.00	604,000.00	43.92
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	305,600,000.00	263,516,125.00	42,083,875.00	86.23
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	282,100,000.00	246,440,825.00	35,659,175.00	87.36
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	23,500,000.00	17,075,300.00	6,424,700.00	72.66
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,000,000.00	2,610,000.00	2,390,000.00	52.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,000,000.00	2,610,000.00	2,390,000.00	52.20
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,000,000.00	2,610,000.00	2,390,000.00	52.20
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	5	5	-	100.00
620001	Удирдах ажилтан	2	2	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	3	3	-	100.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг төлөөлөгч, иргэдийн эргэх холбоонд тулгуурлан орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлыг бие даан шийдвэрлэж, бодлого шийдвэрийг оновчтой тодорхойлж, ажиллах чиг үүрэг бүхий Баянхонгор сумын Засаг даргын эрхлэх хүрээний байгууллага юм.

Тус байгууллага нь Баянхонгор сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 12/80 дугаар тогтоолоор бүтэц орон тоог 6 байхаар баталж, гүйцэтгэлээр 1 албан хаагч ажил хавсран гүйцэтгэж, 5 орон тоотой ажилласан байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг нарийн бичгийн дарга Ж.Бямбасүрэн 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Г.Лхамжав нар зурж, ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын дотоод аудит/аудиторын чиг үүргийг аймгийн Санхүүгийн хяналт-дотоод аудитын газар хэрэгжүүлдэг ба тайлант онд хяналт шалгалт хийгээгүй талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь “Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”, “Төсвийн тухай хууль” болон бусад холбогдох хууль, журмуудыг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны санхүүгийн тайланг “Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,593.5 мянган төгрөгөөр буюу 2.47 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	1,403.2	219.8	(1,183.4)
Бараа материал	21,426.9	23,176.1	1,749.3
Үндсэн хөрөнгө	43,295.6	41,136.3	(2,159.3)
Хуримтлагдсан элэгдэл	(78,615.7)	(48,832.2)	29,783.6
Нийт хөрөнгө	66,125.7	64,532.2	(1,593.5)
Өр төлбөр	-	4,311.6	4,311.6
Цэвэр хөрөнгө, өмчийн дүн	66,125.7	60,220.6	(5,905.1)
Засгийн газрын хувь оролцоо	66,125.7	60,220.6	(5,905.1)
Тайлант үеийн үр дүн	-	(5,905.1)	(5,905.1)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,087.0	2,087.0	-
Нийт өр төлбөр, цэвэр хөрөнгө, өмчийн дүн	66,125.7	64,532.2	(1,593.5)

Тус байгууллага мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдлийг төсөвт бүрэн төвлөрүүлсэн байна.

Тайлант онд орон нутгийн төсвийн санхүүжилтээр 735,703.1 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 692,201.7 мянган төгрөг төвлөрүүлж, үүнээс урсгал үйл ажиллагаанд 658,325.0 мянган төгрөгийг зарцуулж, 33,876.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Авлагын дансны үлдэгдэл 219.8 мянган төгрөг болж буурсан нь байгууллагын нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 193.8 мянга, аймгийн ЗДТГ-аас архивын бланкны үнэ 25.9 мянган төгрөгийн үлдэгдэл байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 23,176.1 мянган төгрөг болж оны эхний үлдэгдлээс 1,749.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 49,623.1 мянган төгрөгөөр бараа материал худалдан авч, 47,873.9 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 41,136.3 мянган төгрөг болж оны эхний үлдэгдэл хөрөнгөөс 2,159.3 мянган төгрөгөөр буурсан нь Баянхонгор сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын тайлант оны 14, 28, 37, 55 дугаар тогтоолоор төсвийн хөрөнгөөр 16,299.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан бол аймгийн ИТХ-ын 2025 оны 07/52 дугаар тогтоолоор 39,800.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг шилжүүлж, сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын 2025 оны 53 дугаар тогтоолоор 8,442.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, данснаас хассан байна.

Тайлант онд байгууллагын программ хангамжид 2,675.0 мянган төгрөгийн 2 төрлийн программ байснаас 6,600.0 мянган төгрөгийн цахим хурлын программ худалдан авч оны эцсийн дансны үлдэгдэл 9,275.0 мянган төгрөг болсон байна. Дээрх программуудаас 175.0 мянган төгрөгийн өртөг бүхий Санхүүгийн тооцоолох групп ХХК-ий "Acolous" программын төлбөрт урсгал зардлаас 473.0 мянган төгрөг төлсөн байна.

Өглөгийн дансны үлдэгдэл 4,311.6 мянган төгрөг болж нэмэгдсэн нь тайлант онд Сангийн яамнаас зардлыг хаасантай холбогдуулан байгууллагад төлөх өглөг үүссэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 538,269.1 мянган төгрөгөөр тооцож дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс Баянхонгор сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуралдааны 2/14 дүгээр тогтоолоор 707,629.7 мянган төгрөгөөр батлагдаж, 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдааны 5/30 дугаар тогтоолоор 735,303.1 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 735,303.1 мянган төгрөг буюу нийт батлагдсан төсвийн 89.5 хувийг зарцуулсан байгаа нь тайлант онд үндсэн үйл ажиллагааны

зардал 48,391.0 мянга, ГХУСАХЗ 25,284.9 мянган төгрөгөөр хэмнэгдэж, оны эцэст гүйлгээ хязгаарласантай холбоотойгоор зарим зардлыг төлөөгүй, өглөг үүссэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
70105 ОН-ын өөрөө удирдах ёсны байгууллага					
1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	571,009.3	522,618.3	48,391.0	91.5
2	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	5,000.0	2,610.0	2,390.0	52.2
3	80825 Багийн ИНХ-ын даргын урамшуулал	32,793.8	31,881.6	912.2	97.2
4	80201 ГХУСАХЗ	126,500.0	101,215.1	25,284.9	80.0
Нийт		735,303.1	658,325.0	77.0	89.5

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

2025 онд байгууллагын хоол, унааны хөнгөлөлтөд орон нутгийн төсвөөс 13,800.0 мянган төгрөг батлагдсан гүйцэтгэлээр 14,092.6 мянган төгрөг зарцуулсан байна. Тус хөнгөлөлтийг Баянхонгор сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны "Дотоод журам"-ын 9 дүгээр зүйлийн 9.10 дахь хэсгийг үндэслэн нарийн бичгийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 02 дугаар "Хоолны зардал олгох тухай" тушаалаар нэг хүнд ногдох хоолны хөнгөлөлтийн нэг өдрийн тарифыг 10.0 мянган төгрөг байхаар баталсан байна.

3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд тус байгууллага нь худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Баянхонгор сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Адилзаяа гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

б

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны нийт санхүүжилтийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны 3 дугаар улирлын байдлаарх нийт санхүүжилтийн дүн болох 735,303.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 7,353.0 мянган төгрөгөөр тооцон аудитыг гүйцэтгэх шатанд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Аудитыг төлөвлөх үе шатанд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хязгаарлалттай холбоотой 55 эрсдэлийг сонгож бүртгэснээс аудитыг гүйцэтгэх явцад тус хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8 дахь заалтыг зөрчсөн 1 зөрчил илэрсэнд зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаcт мэдээлбэл зохих цалингийн зардлаас бусад 5 саяас дээш үнэ бүхий орлогын 679,211.1 мянган төгрөгийн 22 гүйлгээ, зарлагын 118,957.9 мянган төгрөгийн 9 гүйлгээ, бусад оруулбал зохих 153 мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

2024 оны санхүүгийн тайлангийн аудитыг Төрийн аудитын байгууллагын аудитор Ц.Дорж гүйцэтгэсэн бөгөөд аудитаар нийт 64,849.8 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлснийг хугацаанд нь бүрэн биелсэн байна.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	3	64,849.8	3	64,849.8	100
Нийт дүн	3	64,849.8	3	64,849.8	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаашид төсвийн төлөвлөлт, санхүүжилтийн хуваарилалт, өр төлбөрийн удирдлагад эрсдэл үүсэх магадлалтай тул өглөгийг барагдуулах арга хэмжээ авч ажилласан эсэхийг дараагийн аудитаар давтагдсан эсэхийг үзэх шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 115,300.0 мянган төгрөгийн 2 зөрчил⁽⁰⁰⁾ илэрсэнд 1,850.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 113,450.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлэв.

Аудитаар илэрсэн материаллаг зөрчлийн дүн нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшингээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгөв.

5.1 Зөвлөмж

5.1.1 Тайлант онд төлөөлөгчдийн зардалд олгосон нийт 113,450.0 мянган төгрөгийн санхүүгийн анхан шатны баримт бүрдэл дутуу, төсвийн гүйцэтгэлийн тайлан байхгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь “Хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, УСНББОУС-30 Санхүүгийн хэрэглүүр: тодруулга, НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.4-т “Голч, бодитой байх, санхүүгийн тайланд багтсан мэдээлэл ямар нэгэн нөлөөнд автаагүй байх” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн анхан шатны баримтын бүрдүүлэлтийг хийж бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, биелэлтийг нотлох баримтын хамт 2026 оны 12 дугаар сарын 10-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх зөвлөмж хүргүүлэв.

5.2 Албан шаардлага

5.2.1 Баянхонгор сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 60 дугаар тогтоолоор "Шатар сонирхогчдын сумын аварга шалгаруулах тэмцээн" зохион байгуулж 1,850.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх "Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.8 дахь "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна. Шийдвэрлэсэн нь: Зөрчлийн таслан зогсоох, цаашид Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хязгаарлалттай холбоотой арга хэмжээг төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхгүй байх, биелэлтийг нотлох баримтын хамт 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх албан шаардлага хүргүүлэв.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Баянхонгор сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 60 дугаар тогтоолоор "Шатар сонирхогчдын сумын аварга шалгаруулах тэмцээн" зохион байгуулж 1,850.0 мянган төгрөг зарцуулсан байна.	1	1,850.0			1	1,850.0		
Тайлант онд төлөөлөгчдийн зардалд олгосон нийт 113,450.0 мянган төгрөгийн санхүүгийн анхан шатны баримт бүрдэл дутуу, төсвийн гүйцэтгэлийн тайлан байхгүй байна.	1	113,450.0					1	113,450.0
Дүн	1	115,300.0			1	1,850.0	1	113,450.0

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-----oOo-----